

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:


“XIX.10. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлыг холбогдох гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.

2. Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.

3. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (салбар төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай, хашаа)-ын хүрээнд хийгдэх ажлыг батлагдсан ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, төсвийн дагуу эхлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт зөвшөөрч, уг дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг тухай бүр шуурхай шийдвэрлэж байхыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баярмагнай)-д даалгав.

4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР